



**ХӨВСГӨЛ АЙМГИЙН
ЦЭЦЭРЛЭГ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 02 сарын 13 өдөр

Дугаар 1/16.

Халбан

Зорчих хөдөлгөөн хязгаарлах тухай

Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.12 дэхь заалт, 59.1.23, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32.1.8, Захиргааны ерөнхий хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 40 дүгээр зүйлийн 40.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Цасан шуурга шуурч үзэгдэх орчин хязгаарлагдмал байгаа тул 2024.02.13-наас 2024.02.14-ийг хүртэл хугацаанд сумаас гарах авто тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг түр хугацаанд хязгаарласугай.

2. Сумын төвөөс гарах авто тээврийн хэрэгслийн хөдөлгөөнд хяналт тавьж, иргэдийн төөрөх, осгож болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлж ажиллахыг Орлогч дарга (Д.Отгонбаяр), цагдаа (Ч.Сүхбат), багийн засаг дарга нарт даалгасугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг сумын онцгой комиссын нарийн бичгийн дарга, Засаг даргын Тамгын газрын дарга (Б.Бямбажав)-д даалгасугай.

ДАРГА



Д.ОТГОНБАЯР